


БАТЛАВ

ЗАХИАЛАГЧ:



НИЙЛҮҮЛЭГЧ:



Цус Сэлбэлт Судлалын Үндэсний төв"-д оношлуур нийлүүлэх гэрээ.

Дугаар № 2016 он 01

Улаанбаатар хот

Нэг талаас *Цус сэлбэлт судлалын үндэсний төв* (цаашид "захиалагч" гэх), нөгөө талаас *Монбиофарм Трейд ХХК* (цаашид "нийлүүлэгч" гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2016 оны 02 сарын 05-ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид "гэрээ" гэх) байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
- 1.2 Захиалагч нь Цус Сэлбэлт Судлалын Үндэсний төв"-д оношлуур нийлүүлэх №2016/01 дугаартай тендерийн "Лабораторийн дагалдах хэрэгслийн 9-р багцын бараануудыг нийт **38,422,000**(гучин найман сая дөрвөн зуун хорин хоёр мянган) төгрөгөөр нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
- 1.3 Захиалагч нь барааны нийлүүлэлтийг нийт **38,422,000** төгрөгийн төвлөрсөн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
- 1.4 Нийлүүлэгч нь барааг 2016 оны 02 дугаар сарын 1-ноос 2016 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
- 1.5 Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:
 - 1.5.1 Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл

- 1.5.2 Бусад шаардлагатай баримт бичиг¹;
- 1.5.3 Тендер ба үнийн хуваарь;
- 1.5.4 Гэрээний тусгай нөхцөл;
- 1.5.5 Гэрээний ерөнхий нөхцөл;
- 1.5.6 Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
- 1.5.7 Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

- 1.6 Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.
- 1.7 Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
- 1.8 Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

Хоёр. Захиалагчийн эрх, үүрэг

- 2.1. Захиалагч нь 1.4-т дурдсан хугацаанд нийлүүлэгдсэн барааг хүлээн авч, хүлээн авсан тухай баримт бичиг болон нийлүүлэгчийн нэхэмжлэхийг үндэслэн 20 хоногийн дотор төлбөрийг нийлүүлэгчийн данс руу шилжүүлэх үүрэгтэй.
- 2.2. Захиалагч нь гэрээгээр тохиролцсон төлбөр төлөх хугацааг хэтрүүлсэн тохиолдолд нэхэмжилсэн нийт үнийн дүнгийн 0.1%-тай тэнцэх алдангийг хэтрүүлсэн хоног тутамд нийлүүлэгчид төлөх үүрэгтэй.
- 2.3. Захиалагч нь нийлүүлэгчийн нийлүүлсэн бараа техникийн тодорхойлолтын шаардлага хангаагүй, эсвэл нийлүүлэгч нь гэрээний бусад үүргээ биелүүлээгүй тохиолдолд нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээг бүхэлд нь болон хэсэгчлэн цуцлах үүрэгтэй.

Гурав. Гүйцэтгэгчийн эрх үүрэг

3.1. Нийлүүлэгч нь гэрээний бүх нөхцөл, техникийн тодорхойлолтонд нийцсэн барааг нийлүүлэх үүрэгтэй.

3.2. Барааны шошго нь тендерийн материалд заасны дагуу англи хэл дээр бичигдсэн байна.

3.3. Нийлүүлэгч нь барааг шаардлагын дагуу зөв тээвэрлэн хүргэх нөхцөлийг хангах асуудлыг бүрэн хариуцана.

3.4. Нийлүүлэгч нь барааны тоо хэмжээг дутаах, нийлүүлэх хугацааг хоцроох асуудал гаргасан тохиолдолд гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээгээр хоногийн 0,1%-ийн алдангийг захиалагчид төлнө.

Дөрөв. Хүчинтэй хугацаа

Гэрээ нь нийлүүлэгч барааг захиалагчид хүлээлгэн өгч, төлбөрийг дансаар хүлээн авч дуусах хүртэл хүчинтэй байна.

Тав. Бусад зүйл

5.1. Талууд гэрээнд холбогдох асуудлаар албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

5.2. Гэрээ хэрэгжүүлэхтэй холбоотой үүссэн аливаа маргааныг талууд зөвшилцлийн журмаар шийдвэрлэх ба зөвшилцөх боломжгүй болсон тохиолдолд ХАҮТ-ын дэргэдэх арбитрын шүүхээр шийдвэрлүүлнэ.

Уг гэрээ нь монгол хэл дээр 2 хувь хийгдсэн ба талууд гарын үсэг зурж, тамга дарснаар хүчинтэй болно.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:
Цус Сэлбэлт Судлалын Үндэсний
Төвийн ерөнхий нябо Д. Гүнжээ

Хаяг: Сүхбаатар дүүрэг
Энхтайвны өргөн чөлөө
Утас: 326504
Факс: 976-11- 312857

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ :
Монбиофарм трейд ХХК менежер

3.Тувшинбаяр
.....
.....
.....

Хаяг: СБД, 4-р хороо 69-1

Утас:976-11-330234, факс:70120304

Монгол улсын гадна үйлдвэрлэгдсэн

бөгөөд импортоор орж ирэх барааны үнийн хуваарь

огноо:2016.02.05

НТШ-ын дугаар : 2016 он 01

Багц 9. Шинжилгээний дагалдах хэрэгсэл

№	Барааны ерөнхий нэршил	Барааны олон улсын нэршил	Эмийн хэлбэр	Савлалтын хэлбэр	Үйлдвэрлэсэн улс	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Бүгд үнэ
1	Вакумтнер хуруу шил зүүний хамт 7 мл	Vacurette EDTA 7 ml	Хуруу шил	ширхэг	БНХАУ	25500	210	5355000
2	Вакум тнер хуруу шил 5 мл EDTA	Vacurette EDTA 5 ml	Хуруу шил	ширхэг	БНХАУ	25500	210	5355000
3	Вакум тнер хуруу шил 5 мл /хоосон/	Vacurette red cup 5 ml	Хуруу шил	ширхэг	БНХАУ	25500	210	5355000
4	Гельтэй хуруу шил 5 мл	Vacurette gel 5 ml	Хуруу шил	ширхэг	БНХАУ	25500	270	6885000
5	хуруу шил 3 мл/10*75/	Class tube 3 ml	Хуруу шил	ширхэг	Бельги	10000	250	2500000
6	цитраттай хуруу шил /5мл/	Vacurette citrate 5 ml	Хуруу шил	ширхэг	БНХАУ	600	270	162000
7	Вакумтнер хуруу шил бактерлоги 10 мл	Vacurette Plain 10 ml	Хуруу шил	ширхэг	Герман	7200	650	4680000
8	Пипетикны хошуу жижиг	Pipette tips 5-200mkl	Хуруу шил	багц	Герман	200	15000	3000000
9	Өндөг цоологч	lancet	Багаж	хайрцаг	Солонгос	2000	50	100000
10	Пипетикны том хошуу	Pipette tips 1000mkl	Багаж	багц	Герман	15	20000	300000
11	Эппендорф / 1,8 мл/	Pp tube 1,8 ml	Багаж	ширхэг	Солонгос	6000	400	2400000
12	Эппендорф / 3 мл/	Eppendorf	Багаж	ширхэг	Солонгос	3000	50	150000
13	Петрийн аяга	Petr dish	Багаж	ширхэг	Герман	100	300	30000
14	нэг удаагийн дусаагуур	plastic pipette	Багаж	ширхэг	Солонгос	30000	30	900000

Багц 9. Шинжилгээний дагалдах хэрэгсэл Бараа нийлүүлэлтийн хуваарь

№	Барааны ерөнхий нэршил	Барааны олон улсын нэршил	Эмийн хэлбэр	Савлалтын хэлбэр	Шаардлагатай тоо хэмжээ	Нийлүүлэх хугацаа
1	Вакуумтeнер хуруу шил зүүний хамт 7 мл	Vacuette EDTA 7 ml	Хуруу шил	ширхэг	25500	2 сарын 17
2	Вакуум тeнер хуруу шил 5 мл EDTA	Vacuette EDTA 5 ml	Хуруу шил	ширхэг	25500	2 сарын 17
3	Вакуум тeнер хуруу шил 5 мл /хоосон/	Vacuette red cup 5 ml	Хуруу шил	ширхэг	25500	2 сарын 17
4	Гельтэй хуруу шил 5 мл	Vacuette gel 5 ml	Хуруу шил	ширхэг	25500	2 сарын 17
5	хуруу шил 3 мл/10*75/	Class tube 3 ml	Хуруу шил	ширхэг	10000	2 сарын 17
6	цитраттай хуруу шил /5мл/	Vacuette citrate 5 ml	Хуруу шил	ширхэг	600	2 сарын 17
7	Вакуумтeнер хуруу шил бактерлоги 10 мл	Vacuette Plain 10 ml	Хуруу шил	ширхэг	7200	2 сарын 17
8	Пипетикны хошуу жижиг	Pipette tips 5-200mkl	Хуруу шил	багц	200	2 сарын 17
9	Өндөг цоологч	lancet	Багаж	хайрцаг	2000	2 сарын 17
10	Пипетикны том хошуу	Pipette tips 1000mkl	Багаж	багц	15	2 сарын 17
11	Эппендорф / 1,8 мл/	Pp tube 1,8 ml	Багаж	ширхэг	6000	2 сарын 17
12	Эппендорф / 3 мл/	Eppendorf	Багаж	ширхэг	3000	2 сарын 17
13	Петрийн аяга	Petr dish	Багаж	ширхэг	100	2 сарын 17
14	нэг удаагийн дусаагуур	plastic pipette	Багаж	ширхэг	30000	2 сарын 17
15	эффендорф	Eppendorf 50 ml	Багаж	ширхэг	1000	2 сарын 17
16	Пергаментийн цаас	Paper	цаас	кг	80	2 сарын 17